



ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү баримт бичгээр "Нэткапитал финанс корпораци ББСБ" ХХК (цаашид "Групп" гэх)-ийн цалин, урамшууллын үндсэн зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.
- 1.2. Энэхүү баримт бичгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр Группийн толгой, охин, зэргэлдээ, хараат компаниудын үйл ажиллагаанд мөрдөж болно.
- 1.3. Группийн үйл ажиллагааны чиглэл, онцлогт тохируулан зах зээлд өрсөлдөхүйц хэмжээтэй цалин, урамшууллыг тогтоох зарчмыг баримтална.

ХОЁР. ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1. Цалин, урамшууллын талаар группийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.1.1. Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох;
 - 2.1.2. Цалин, урамшууллын жишиг тогтоох, хуваарилалтад аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлыг гаргахгүй байх;
 - 2.1.3. Цалин, урамшууллыг мэдлэг, ур чадвар, туршлага болон ажлын үнэлгээ, гүйцэтгэл, үр дүнд суурилж тогтоох;
 - 2.1.4. Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцын түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангах;
 - 2.1.5. Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалын дагуу ажилтнуудын цалин, урамшууллыг шударга хуваарилах, хөдөлмөрчдийн эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр болон хамтын гэрээ байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх.
- 2.2. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо (цаашид "Хороо" гэх) нь группийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад олгох цалин, урамшууллын дээд, доод хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлын хүрээнд дараах хэлбэрээр, зохистой хэмжээг тогтоон олгоно. Үүнд:
 - 2.2.1. Группийн цалингийн бүтэц, жишгийг тогтоох;
 - 2.2.2. Хуралд оролцсон цалин;
 - 2.2.3. Группийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалсан бусад хэлбэрийн мөнгөн болон мөнгөн бус урамшуулал.
- 2.3. Хороо нь эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг ТУЗ-өөр батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргана.
- 2.4. Хороо нь группийн ажилтануудын цалин, урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавих, группийн цалингийн бодлого, түвшин, бүтэц, цалин тогтоох журамд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д тайлагнаж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- 2.5. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарна.
- 2.6. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилт, боловсронгуй болгох ажлыг тухай бүр хийнэ.